



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/205

Номгон

Г Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.7, 15 дугаар зүйлийн 15.1, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-143 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улс, аймаг, сум орон нутгийн хөрөнгөөр бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулах хариуцлагатай ажилтныг томилон, ажлын хэсэг байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Бактержуулсан бэлдмэл цацах стандарт, заавар, зөвлөмжийн дагуу хүн, малын аюулгүй байдлыг ханган будаа цацах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, холбогдох дүгнэлтийг гаргаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (У.Балжинням), сумдын Засаг дарга, ажлын хэсэгт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН

642310565

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 17/2023 дугаар захирамжийн хавсралт



2023 ОНД БЭЛЧЭЭРИЙН ХОРТОН МЭРЭГЧТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Сумын нэр	Сумын ОНХСангийн хөрөнгөөр микробиологийн аргаар тэмцэх			Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр микробиолгийн аргаар тэмцэх			Улсын төсвөөс олгож буй дэмжлэг					Хугацаа
		Баталсан хөрөнгий н хэмжээ /сая.төг/	Авах бактержуулса н будааны хэмжээ /тн/	Цацах талбай н хэмжээ /га/	Баталсан хөрөнгий н хэмжээ /сая.төг/	Авах бактержуул сан будааны хэмжээ /тн/	Цацах талбайн хэмжээ /га/	Микробиологийн арга		Энгийн механик арга			
								Бактер жуулсан будааны хэмжээ /тн/	Цацах талбайн хэмжээ /га/	Нэг бүрий н үнэ /төг/	Цацах талбай н хэмжээ /га/	Нийт хөрөнгө /төг/	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1	Бууцагаан	5.5	1.0	667				3.0	2,000	1600	2,500	4,000,000	2023 оны 04 дүгээр сарын 25- наас 05 дугаар сарын 01- ний хооронд
2	Баянбулаг	5.5	1.0	667				4.0	2,667	1600	2,500	4,000,000	
3	Гурванбулаг	5.5	1.0	667				3.0	2,000	1600	2,500	4,000,000	
4	Заг	5.5	1.0	667	5.5	1.0	667	1.5	1,000	1600	2,500	4,000,000	
5	Жаргалант	16.5	3.0	2,000				4.0	2,667	1600	6,000	9,600,000	
6	Эрдэнэцогт	5.5	0.8	533				1.5	1,000	1600	2,500	4,000,000	
7	Баян-Овоо	11.0	1.8	1,200				1.0	667	1600	4,000	6,400,000	
8	Өлзийт	8.25	1.5	1,000				0.5	333	1600	3,500	5,600,000	
9	Галуут				5.5	1.0	667	0.5	333				
10	Бөмбөгөр	11.0	2.0	1,333				1.0	667	1600	4,000	6,400,000	
<b>Нийт дүн</b>		<b>74.25</b>	<b>13.1</b>	<b>8,733</b>	<b>11.0</b>	<b>2.0</b>	<b>1,334</b>	<b>20.0</b>	<b>13,333</b>	<b>-</b>	<b>30,000</b>	<b>48,000,000</b>	

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

160